



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/10

Хэрлэнбаян-Улаан тосгон

**Хагас жилийн эд хөрөнгийн тооллогын
комисс томилох тухай**

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 67 дугаар зүйлийн 67.5, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 78 дугаар зүйлийн 78.2.4, 72 дугаар зүйлийн 72.1, 72.2, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захирагчийн ажлын албаны эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Энхсаруул – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүд: Х.Балжидмаа – Архив, бичиг хэргийн эрхлэгч
Н.Ууганзаяа – Үйлчлэгч

2. Захирагчийн ажлын албаны 2025 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг комиссын дарга (Б.Энхсаруул)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.ОТГОНБАЯР

